

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүнээс 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 05 дугаар сарын 28-ний нэгдсэн хуралдаанаар, Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.26-д “Нэг асуудлаар 2 ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг анхны хэлэлцүүлгийн шатанд нэгтгэн 1 төсөл болгож Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ” гэж заасны дагуу Төсвийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаараа нэгтгэсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн татварын харилцааг зохицуулсан хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаар ахлуулан 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Нэгтгэсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал албан татвар төлөгчийн амьдран суух зориулалттай орон сууцаа борлуулсан орлогыг татвар ногдуулах орлогоос чөлөөлөхдөө анх удаа өмчилсөн буюу нэг удаа чөлөөлөх гэсэн агуулгаар хязгаарлалт тогтоож байгаа эсэхийг тодруулж, хүн амын орлогын албан татварын бодлогоор бага, дунд орлоготой иргэн, өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх зорилготой татвар ногдуулалтын хувийг тэглэж байгаа нь тухайн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлоготой нийцэх эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар нэгтгэсэн хуулийн төслийг хэлэлцэх үед ажлын хэсгээс хувь хүний орлогын албан татвар ногдуулах хувь хэмжээг 1 хувь болгох зохицуулалтыг 4-5 шатлалтай болгох буюу сарын 792.0 мянган төгрөг хүртэлх орлогод 0 хувиар, 792.0 мянган төгрөгөөс 2.0 сая төгрөг хүртэл орлогод 1

хувиар албан татвар ногдуулах хувь хэмжээг нэмэх зохицуулалтыг үе шаттай хэрэгжүүлэхээр өөрчлөх, мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хуулийн нэр томьёог хоёрдмол утгагүй, товч тодорхой илэрхийлэх нийтлэг шаардлагын хүрээнд боловсруулахтай холбоотой зарчмын зөрүүтэй 6 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн нэгтгэсэн хуулийн төсөлтэй холбогдуулан төрөөс олгосон хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хадгалуулсан хадгаламжийн хүүгийн орлого, татварын жилийн баталгаажсан тайлангаар 400 сая хүртэлх төгрөгийн албан татвар ногдох орлоготой хувь хүний хүсэлтэд үндэслэн түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох зэрэг зарчмын зөрүүтэй 9 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, нэгтгэсэн хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР